

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын
сайдын 2025 оны ...дугаар сарын ...-ний
өдрийн ... дугаар тушаалын хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ,
БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, УГСРАЛТ, ЗАСВАР
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү нөхцөл шаардлагын зорилго нь барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын угсралтын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээг эрхлэх /Цаашид “барилгын үйл ажиллагаа” гэх/ хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл /Цаашид “Зөвшөөрөл” гэх/-ийг олгоход баримтлах нөхцөл, шаардлага, үйлчилгээний хөлсийг тогтоох, тэдгээр нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийн гэрээ, гэрчилгээний загварыг батлахад оршино.

1.2. Барилгын үйл ажиллагааны зөвшөөрлийн нөхцөл, шаардлага нь барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын угсралтын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээг эрхлэх хуулийн этгээдийн үйл ажиллагааг барилга, байгууламжийн норм нормативын баримт заасан шаардлагад нийцүүлэхэд чиглэнэ.

Хоёр. Ерөнхий нөхцөл, шаардлага

2.1. Барилгын үйл ажиллагааны зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан өргөдөл, энэ нөхцөл, шаардлагад тусгагдсан үйл ажиллагааны чиглэл тус бүрт хамаарах нөхцөл, шаардлагыг хангасан талаар материалаа бүрдүүлэн, хууль тогтоомжид заасан хугацаанд тусгай зөвшөөрлийн цахим системээр болон баталгаажуулсан хэвлэмэл хэлбэрээр ирүүлсэн байх.

2.2. Гадаадын хуулийн этгээд нь барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа Барилгын тухай хууль болон энэ нөхцөл шаардлагад заасан баримт бичиг бүрдүүлэхээс гадна тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах гэрчилгээний хуулбар, баталгаат орчуулгын эх хувийг хавсарган ирүүлэх бөгөөд Барилгын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3-д заасан шаардлагыг хангасан байна.

2.3. Энэхүү нөхцөл, шаардлагыг хангасан барилгын үйл ажиллагааны чиглэл бүрээр шаардлагатай мэргэжлийн ажилтантай байх.

2.4. Олон Улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын гишүүн 38 улсын аж ахуйн нэгж , байгууллагуудын болон ОХУ, БНХАУ,

Энэтхэг улсуудын инженер техникийн ажилчдын мэргэжлийн дипломыг Монгол Улсад суралцаж төгссөн инженер техникийн ажилчдын мэргэжлийн дипломтой адилтгах.

2.5. Зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй инженер нь 4 хүртэл аж ахуй нэгж, байгууллагад, мэргэшсэн зэрэгтэй инженерийн 2 хүртэл аж ахуй нэгж, байгууллагад бүртгүүлэх.

2.6. Бусад салбарын зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй инженерийн баримт бичгийг барилгын салбарын зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй адилтгах.

2.7. Хос мэргэжилтэй салбарын инженер, техникийн ажилтан нь тухайн мэргэжил тус бүрийг давхацуулалгүйгээр өөр өөр байгууллагууд бүртгэх.

2.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан нь ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтад хамрагдсан байна. ХАБЭА-ны хөтөлбөрөөр коллеж, МСҮТ, их, дээд сургууль төгссөн ажилтантай тохиолдолд уг баримт бичгийг шаардахгүй.

2.9. Инженер, техникийн ажилтны мэдээлэлд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд баталгаажсанаас хойш 90 хоногийн дараа шилжилт хөдөлгөөн хийж болох ба шилжилт хөдөлгөөн хийсэн тохиолдолж орон гарсан инженер, техникийн ажилтныг 60 хоногийн дотор нөхөх, уг шаардлагыг биелүүлээгүй бол нөхцөл шаарлагыг хангахгүй болсон гэж үзнэ.

2.10. Зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ нөхцөл шаардлагыг ... дүгээр хавсралтаар баталсан үйлчилгээний хөлсийг төлсөн байх.

2.11. Барилгын үйл ажиллагааны зөвшөөрлийн гэрээ нь тоон гарын үсэг, QR код (түргэн хариултын код)-той, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь QR кодтой байна.

2.12. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл сунгуулах, нэмэлт ажлын төрөл авах бол тусгай зөвшөөрөл эзэмшиж байх хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын гэрээ, Барилгын салбарын норм нормативын санд төлбөр төвлөрүүлсэн баримтыг ирүүлсэн байх.